



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/74

Номгон

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Отгонбаяр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Наранбаяр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


Т.Ганболд -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Отгонжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

2.Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, танилцуулахыг Ажлын хэсэг (П.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310159